



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 13 өдөр

Дугаар A-31

Улаанбаатар хот

### Арилжаанд оролцох эрхийг хязгаарлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10.11 дэх заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Гишүүнчлэлийн журам”-ын 5 дугаар зүйлийн 5.2.3.2 дахь заалт, “Гишүүнчлэлийн гэрээ”-ны 2 дахь хэсэг 2.4.3.1, 2.4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Гишүүнчлэлийн гэрээ”-ээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй хавсралтад дурдсан нэр бүхий 8 компанийн үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг тус гэрээний дагуу түр хязгаарлах арга хэмжээг 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн үүрэг биелэгдэх хүртэл хугацаанд авсугай.
2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

“МХБ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын  
2017 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн  
А-31 дугаар тушаалын хавсралт



**Үнэт цаасны арилжаанд оролцох эрхийг  
түр хязгаарлах арга хэмжээ авагдах  
гишүүн үнэт цаасны компаниудын нэрс**

1. "Азиа Пасифик Секьюритис ҮЦК" ХХК
2. "Аргай Бэст ҮЦК" ХХК
3. "Асе энд Т Капитал ҮЦК" ХХК
4. "Гацуурт Трейд ҮЦК" ХХК
5. "Евразиа Капитал Холдинг ҮЦК" ХК
6. "Монсек ҮЦК" ХХК
7. "Нэйшнл Секьюритис ҮЦК" ХХК
8. "Санар ҮЦК" ХХК

---oO---